

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 01 сарын 28 өдөр

№ 04

Дархан уул аймаг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагт “Тээвэр дархан” ХК-ийн офисын хурлын танхимд эхлэв.

Хурлын ирц: 96.6%

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн бүртгэлд хувьцаа эзэмшигч “Монгол Алт” ХК, Ж.Мөнхтөр нарыг итгэмжлэлээр төлөөлөн оролцогч М.Цолмон, хувьцаа эзэмшигч Л.Амарсанааг итгэмжлэлээр төлөөлөн оролцогч А.Болор-Эрдэнэ, хувьцаа эзэмшигч М.Оюун, Л.Энхсайхан, Т.Дансран, Н.Одонтуяа нар бүртгүүлэн хуралд оролцов. Дараах хувьцаа эзэмшигч Г.Чимгээ, Гацуурт трейд, Ц.Хуяг, Т.Самданжигмэд, Б.Цэрэн, Ж.Батчулуун, Д.Сумьяа, Н.Алтанцэцэг, Ч.Эрдэнэчимэг нар бүртгэлтэй үнэт цаасны компаниараа дамжуулан саналын хуудсаа ирүүлсэн. Урьдчилсан байдлаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчийг тус хуралд оролцсонд тооцож бүртгэнэ гэсний дагуу ирцэд оруулсан болно.

Ж.Очирсүх: - Нарийн бичгийн дарга Э.Жавхлантөгс ирцийг танилцуулна уу.

Э.Жавхлантөгс: - Компанийн нийт энгийн 163349 ширхэг хувьцаанаас 157938 ширхэг энгийн хувьцааг эзэмшигчид буюу 96.6 хувийн ирцтэйгээр хурал эхлэв.

Ж.Очирсүх: - Энэ удаагийн хурлыг даргалах хүнийг сонгон томилох юм байна.

Одоо “Тээвэр дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Очирсүхийг хурлын даргаар сонгох саналтай хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Ээлжит бус хуралдаанд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрлөө. Татгалзсан, түдгэлзсэн хүн байхгүй байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Очирсүхийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар томилсныг нийт хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид 100 хувь санал нэгтгэйгээр зөвшөөрөв.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журмыг танилцуулъя. Өнөөдөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай,

Хоёрдугаарт, Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай,

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлахыг зөвшөөрч байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Хуралдаанд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрлөө.

(Хурлын дарга Ж.Очирсүх хурлын дотоод журмыг танилцуулав).

Саналтай Хувьцаа эзэмшигч байна уу?

Хурлын дотоод журамд саналтай хүн байна уу? Байхгүй.

Хурлын дотоод журмыг баталъя гэж байгаа Хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү. Санал нэгтгэйгээр дэмжиж байна.

Ж.Очирсүх: - Асуудлаа хэлэлцэж эхлэхийн өмнө нэг зүйлийг тодотгож хэлэх ёстой. Хэлэлцэж байгаа хоёр асуудал бол манай компанийн толгой буюу хараат компани болох "Монгол Алт" ХК-ийн хэрэгжүүлж байгаа орон сууцны барилгын төслийг банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх зорилгоор манай компани өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө, газруудыг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангуулах хэлбэрээр барьцаалуулах зөвшөөрөл олгох асуудалтай холбоотой юм.

"Тээвэр Дархан" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуралдаж 07 дугаартай тогтоолоороо "Монгол Алт" ХК-ийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Хаан банк" ХК-иас зээл авах, компанийн эзэмшилд буй үл хөдлөх хөрөнгүүдийг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангуулах хэлбэрээр барьцаалуулах зөвшөөрөл олгож, холбогдох гэрээ хэлцэл байгуулах, барьцааны гэрээнд "Тээвэр Дархан" ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал М.Оюунд олгосон шийдвэрийг гаргаж, холбогдох журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

Гэвч Санхүүгийн зохицуулах хорооноос "Тээвэр Дархан" ХК-ийн нийт хувьцааны 51 хувийг эзэмшдэг толгой компани болох "Монгол Алт" ХК-ийн зээлийн барьцаанд компанийн өөрийн үл хөдлөх хөрөнгө болон газрыг барьцаалах асуудлыг Компанийн тухай хууль болон холбогдох журмын дагуу "Тээвэр Дархан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулан шийдвэрлэх шаардлагатай болохыг зөвлөсөн хариу ирүүлсэн юм.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах гол шалтгаан нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.3-т "Хувьцаат компанийн хувьд дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана", мөн зүйлийн 92.3.1-т "энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаатай холбоотой юм.

Ийм учраас Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.3, 2.10 дахь хэсэгт тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр зарлаж, хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах зохицуулалттай байдаг. Энэ дагуу "Тээвэр Дархан" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 12 сарын 18-ны өдөр хуралдан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа 2026 оны 01 сарын 28-ны өдөр зарлан хуралдуулахаар товлосон юм.

Тэгэхээр сонирхлын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргах тул сонирхлын зөрчилтэй хувьцаа эзэмшигч саналын эрхгүй, санал өгөхгүй гэсэн үг.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

ХЭЛЭЛЦСЭН нь: - Асуудлаа хэлэлцье. Сонирхлын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийх тухай асуудлуудыг хэлэлцэнэ. "Монгол Алт" ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Цолмон, "Тээвэр Дархан" ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Оюун нар танилцуулна.

М.Цолмон: - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдаанд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Манай компани орон нутгийн төслүүд 3 дахь жилдээ хэрэгжүүлээд үргэлжилж байна. Та бүхний мэдэх "Голден таун" хотхоны төсөл эхний блок ашиглалтад ороод одоо 2, 3 дугаар блокуудын угсралт хийгдээд 50 хувьтай үргэлжилж байна. Үргэлжлүүлэн санхүүжүүлэх зорилгоор хүсэлт тавьсаны дагуу өнгөрсөн оны 11 сараас Хаан банкны зээлийн эдийн засагч нар судалж, барьцаа хөрөнгүүдийг үнэлж эхэлсэн юм. Ингээд манай "Тээвэр Дархан" ХК-ийн эзэмшлийн хөрөнгүүдийг барьцаалбартаа оруулж хамтран зээлдэгч болох саналыг тавьсан. Нийт 10 тэрбум төгрөгийн зээл авахаар төлөвлөгдсөн байгаа. Эхний ээлжинд "Монгол Алт" ХК-ийн барьцаалбарт ногдох 5 тэрбум төгрөгийн зээлийг авч хүлээлгэсэн байсан ажлын гүйцэтгэлүүдийн төлбөрийг төлж барагдуулсан байгаа.

Ж.Очирсүх даргын тодотгож хэлсний дагуу "Тээвэр Дархан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар сонирхолын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Хурлаас гарсан шийдвэрийг 3 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж "Тээвэр Дархан" ХК-ийн эзэмшлийн хөрөнгүүдийг зээлийн барьцаалбарт бүртгүүлэх зөвшөөрөл авах юм.

Ж.Очирсүх: - За, Цолмон захирал нөхцөл байдлыг танилцуулчихлаа. Сонирхлын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийх асуудлаар санал хэлэх, асуулт асуух эрх манай компанийн сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчидэд байгаа.

Хуралд хүрэлцэн ирж оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд асууж тодруулах зүйл байна уу?

Л.Энхсайхан:- Асуулт алга. Ойлгомжтой байна.

Т.Дансран: - Асуух зүйл байхгүй. Саналыг зөвшөөрч байна.

Н.Одонтуяа: - Асуух зүйл байхгүй. Зөвшөөрч байна.

Ж.Очирсүх: - Манай компанийн зарим хувьцаа эзэмшигчид үнэт цаасны компаниараа дамжуулаад хэлэлцэх асуудалтай танилцаад саналаа ирүүлсэн байна. Бүгд дэмжсэн санал ирүүлжээ.

Тэгэхээр сонирхлын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргах тул 100 хувь дэмжигдлээ.

Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулъя.

"Сонирхлын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай.

Компанийн тухай хуулийн 61.1.5 дахь заалт, 61.4. дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.3 дахь хэсэг, "Тээвэр Дархан" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам"-ын 3.6 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны

өдрийн 08 дугаар тогтоол, "Тээвэр дархан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 01, 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тээвэр Дархан" ХК-ийн хараат буюу толгой компани болох "Монгол Алт" ХК-ийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Хаан банк" ХК-иас 10,000,000,000.0 (арван тэрбум) төгрөгийн барилгын зээл авах, компанийн өөрийн эзэмшлийн, улсын бүртгэлийн Y-2003020673, Y-2003020671, Y-2003020679, Y-2003020674, Y-2003020680, Э-2003002006 дугаар бүхий үл хөдлөх хөрөнгүүд болон газруудыг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангуулах хэлбэрээр барьцаалуулах зөвшөөрөл олгож, холбогдох гэрээ хэлцэл байгуулах, барьцааны гэрээнд "Тээвэр Дархан" ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (М.Оюун)-д олгосугай.

2. Дээрх сонирхлын зөрчилтэй буюу их хэмжээний хэлцэл нь хуулийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гарган танилцуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Аудитын хороо (Л.Амарсанаа), Ерөнхий нягтлан бодогч (Д.Бямбажаргал) нарт үүрэг болгосугай." гэжээ.

Тогтоол дээр асуулт байна уу? Байхгүй.

Санал байна уу? Байхгүй.

Татгалзсан, түдгэлзсэн хүн байна уу? Байхгүй.

Тогтоол батлагдлаа.

Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал амжилттай явагдаж дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа.

Цаашдаа бүгдээрээ компанийнхаа үйл ажиллагааг сайжруулахын төлөө хамтран зүтгэх болно.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАСАН:



ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
Э.Жавхлантөгс

ХУРЛЫН ДАРГА Ж.ОЧИРСҮХ